



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАТШИРЭЭТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
АЛБАН ДААЛГАВАР**

2025 оны 03 сарын 24 өдөр

Дугаар 01

Эг

Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх
тэмцэх зарим арга хэмжээний тухай

Батширээт суманд 2025 оны 1 дүгээр улирлын байдлаар 3 удаагийн ой хээрийн түймэр гарах эрсдэлүүд бүртгэгдээд байна. Дээрх мэдээг өмнөх 2024 онтой харьцуулахад өссөн дүнтэй байна.

Ой хээрийн гал түймрийн дуудлага бүрд сумын 1,2-р ээлж, орон нутгийн иргэдийн хүчээр тархалтыг газар авхуулалгүй унтраах арга хэмжээг авч байна.

Ус цаг уур орчны шинжилгээний төвөөс 03 дугаар сар олон жилийн дунджаас дулаан, 04 дүгээр сард агаарын температур олон жилийн дунджийн орчим байх төлөвтэй байна. Ирэх 04 дүгээр сард нийт нутгаар олон жилийн дунджийн орчим буюу 3-12мм хур тунадастай байх төлөвтэй байна.

Иймд Улсын Онцгой комиссын 2025 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн “Ой хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх тэмцэх зарим арга хэмжээний тухай” 01 тоот албан даалгавар, Аймгийн Засаг даргын “Ой хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх тэмцэх зарим арга хэмжээний тухай” 01 тоот албан даалгавар гарсантай холбогдуулан сумын хэмжээнд 2025 онд ой хээрийн гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, гал унтраах ажиллагаанд хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах бүх шатны төрийн болон төрийн бус байгууллага, иргэн, хуулийн этгээдийн хамтын ажиллагааг сайжруулах ажлын чанар, үр дүнг дээшлүүлэх болон бодлогыг хангах зорилгоор даалгах нь:

**Нэг. Багийн Засаг дарга нар, албан байгууллагын
дарга, эрхлэгч нарт:**

- 1.1. Гамшгаас хамгаалах тухай хуулийн хэрэгжилтийг хангаж байгууллага, багт сайн дурын хэсгийг байгуулан томилгоожуулж баг байгууллагын гамшгаас хамгаалах төлөвлөгөөг тодотгон батлуулахыг.
- 1.2. Ойн тухай хуулийн холбогдох заалтын хүрээнд ой хээрийн түймэр гарсан үед 1,2-р ээлжид заасан албан тушаалтанд чөлөө олгож дайчилгаанд хамруулж гарсан түймрийг унтраах ажлыг шуурхай зохион байгуулахыг.
- 1.3. Багийн Засаг дарга нар харгалзах нутаг дэвсгэртээ хавар, намар хуурайшилтын үед захирамжаар эргүүл жижүүр томилон ажиллуулах талаар мэдээлэхийг.

23250:001

1.4. Ой хээрийн түймрийн нөхцөл байдал хүндэрч аймаг сумаас нэмэлт хүн хүч дайчлан ажиллах үед бие бүрэлдэхүүний эрүүл мэндийг хамгаалах зорилгоор эрүүл мэндийн төвөөс баг томилон ажиллуулахыг.

**Хоёр. Байгаль орчны хяналтын Улсын байцаагч
Б.Мөнх-Очирт:**

2.1. Ойн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5-д заасныг хэрэгжүүлэн, ой хээрийн гал түймрийн цагийн байдлын тухай мэдээг сумын ЗДТГ-т тухай бүр болон хагас бүтэн жилээр гаргаж өгөхийг.

2.2. Ойн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, Засгийн газрын 106 дугаар тогтоолыг хэрэгжүүлэн ой хээрийн гал түймрээс учирсан хор хохирлыг хуулийн хугацаанд тогтоож тайланд тусгахыг.

2.3. Хуурайшилтын үед нөхөрлөлийн идэвхтэн байгаль хамгаалагчдаас мэдээ авч нэгтгэх, зохион байгуулалтад оруулахыг.

2.4. Ойн тухай хуульд заасан түймрийн аюултай үед ойн сангаас мод бэлтгэх, ойн дагалт баялгийг ашиглах, аялал зугаалгаар явах үйл ажиллагааг тодорхой хугацаагаар хязгаарлах, холбогдох Хан Хэнтий Гутайн даваа Хөмүүл голын Байгалийн цогцолборт газар болон хууль хяналтын байгууллагатай хамтран хяналт тавьж хууль дүрэм журмыг зөрчсөн иргэн, хуулийн этгээдэд авсан арга хэмжээний талаар мэдээлэхийг.

**Гурав. Хэсгийн төлөөлөгч, Цагдаагийн дэслэгч
Р.Болор-Эрдэнэд:**

3.1. Зөрчлийг шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6.10 дахь хэсэгт заасан харьяаллын дагуу зөрчлийг шалган шийдвэрлэх.

3.2. Зөрчлийн тухай хуулийн 7.9 дүгээр зүйлийн 7 дахь хэсэгт заасныг зөрчиж ойн сан бүхий газарт гал түймэртэй тэмцэх түүнээс урьдчилан сэргийлэх талаар хуульд заасан шаардлагыг биелүүлээгүй хүн, хуулийн этгээдэд хариуцлага тооцох.

3.3. Зөрчлийн тухай хуулийн 7.9 дүгээр зүйлийн 10 дахь хэсэгт заасныг зөрчиж ойн тухай хуулиар тогтоосон шаардлагыг биелүүлээгүй хүн, хуулийн этгээдэд хариуцлага тооцох.

Дөрөв. Хөдөө аж ахуйн тасгийн дарга Ж.Ундрахад:

4.1. Ой хээрийн гал түймрийн аюултай үед ургац тариалалт хураалтын үед тариалан эрхэлсэн иргэн, аж ахуй нэгжид гал түймрээс урьдчилан сэргийлэх мэдээ санамж өгч ажиллахыг.

4.2. Ой хээрийн гал түймэр гарсан үед түймэр унтраах ажиллагаанд мал аж ахуй, тариалан эрхлэгчдийн тусгай зориулалтын автомат техник чирэгч механизмаар дэмжлэг үзүүлж ажиллахыг.

Тав. Ойн ангийн дарга Г.Гантуяад:

5.1. 2025 оны 03 дугаар сарын 20-ноос 06 дугаар сарын 10, 09 дүгээр сарын 20-ноос 11 дүгээр сарын 10-ны хооронд хуурайшилтын “аюултай”, “нэн аюултай” зэрэгт хүрсэн үед ойн сангаас мод бэлтгэх, ойн дагалдах нөөцийг ашиглах, аялал зугаалгаар явах болон бусад үйл ажиллагааг хязгаарлах захирамж гаргуулан хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээллийн хэрэгслээр сурталчлахыг.

5.2. Ой хээрийн гал түймэр гарсан үед түймэр унтраах ажиллагаанд ойн мэргэжлийн байгууллагуудыг тусгай зориулалтын автомат техник чирэгч механизмаар дэмжлэг үзүүлж ажиллахыг.

ДАРГА



Б.АЛТАНГЭРЭЛ